

Монголын орчин үеийн түүхийн талаар БНХАУ-ын түүхчдийн баримталж буй үндэстний зарчмыг шүүмжлэх нь

Намжилчойжилын Алтантөгс

МУИС-ийн Түүхийн тэнхимийн багш, доктор (Ph.D)

Цахим хаяг: zarizmatika@hotmail.com

Хураангуй: Энэхүү өгүүлэлд БНХАУ дахь Монголын орчин үеийн түүхийн талаар нийтлэгдсэн бүтээлүүдэд олонтаа давтагддаг “Монгол бол Дундад улсын алдагдсан нутаг юм” хэмээх үзлийн онолын үндсийг хөндөхийг оролдов. Сунь Ятсений “Ардын гурван зарчимд” буй таван үндэстний бүгд найрамдах улсын тухай ойлголт нь Монгол улсыг Хятадын (中国) алдагдсан нутаг хэмээн үзэхэд хятадын түүхчдийг хүргэжээ. Орчин үеийн түүхийг судалж буй хятадын түүхчид ийнхүү Хятад (中国) хэмээх ойлголтыг манжийн Чин улсын хэмжээнд буцаан хэрэглэж буй явдал нь Монгол, Хятадын түүхийн салбар дахь үл ойлголцлын шалтгаан болж байна.

Түлхүүр үгс: Монгол Улс, Хятад улс, Ардын гурван зарчим

Удиртгал

Монгол-Хятадын харилцааны түүхэнд 1949 оноос хойших харилцааг орчин үеийн (contemporary) харилцаа гэж үздэг. Орчин үеийн Монгол-Хятадын харилцаа нь социалист найрамдлын үе, Соёлын хувьсгалын үеийн хүйтрэл, перестройкагийн дулаарал, 1990-ээд оны нээлттэй харилцаа зэрэг үе шатуудыг дамжин хөгжиж ирсэн ба өнөө үед стратегийн түншлэлийн түвшинд хүрч амжилттай хөгжиж байна. БНХАУ бол монгол судлалын нэгэн том төв бөгөөд Монголын түүхийг судлах өөрийн гэсэн олон жилийн уламжлалтай. БНХАУ дахь түүхчдийн дунд Монгол бол урьд цагт Хятадын нэг хэсэг байсан бөгөөд 1946 онд Хятадаас салан тусгаар тогтнож, улмаар 1949 онд БНХАУ-тай дипломат харилцаа тогтоосон өнөөгийн бүрэн эрхт улс гэсэн үзэл түгээмэл бий. Энэ өгүүллээр, Монголын орчин үеийн түүх, Монголын тусгаар тогтнолын талаар хятадын судлаачдын үнэлэлт, дүгнэлтүүд нь ямар онол, зарчимд тулгуурлаж буйг тодруулахыг хичээв.

Ингэхдээ зөвхөн БНХАУ-ын судлаачдыг авч үзсэн ба Хятадын Тайваний эрдэмтдийн хийсэн уг сэдэвт холбогдох олон тооны судалгаанууд нь тусгай нэг сэдэв болохуйц учир энд авч үзээгүй.

Хятад дахь орчин үеийн түүхийн судалгаан дахь “Монголын асуудал”

Хятадын судлаачдаас Монгол-Хятадын орчин үеийн харилцааны түүхэнд холбогдох архивын баримт, материал, үйл явдлын он дарааллын бүртгэлийг нийтлүүлэх ажлыг тодорхой хэмжээнд хийж ирсэн боловч хятадын архивын баримтууд тэр бүр нээлттэй байдаггүйгээс шалтгаалан орчин үеийн Монгол-Хятадын харилцааны түүхийн судалгаа өнөөдөр ч эхлэлийн шатандаа явж буй. 1984 оны “Хятадын гадаад худалдаа, эдийн засгийн жил тутмын эмхтгэлд”¹ Монгол-Хятадын 1949 оноос хойших жил тутмын худалдааны дүн хэмжээг, 1987 онд “БНХАУ-ын гадаад эдийн засаг, худалдааны харилцааны үйл явдлын тэмдэглэл (1949-1985 он)” бүтээлд² орчин үеийн Монгол-Хятадын худалдаа, эдийн засгийн харилцааны зарим чухал үйл явдлын он дарааллыг бусад улсуудтай хамтатган эмхэтгэн хэвлүүлсэн нь дипломат харилцаа тогтоосноос хойших хоёр улсын харилцааны чухал үйл явдал ба худалдааны хэмжээг Хятадын талаас нийтлүүлсэн чухал эх сурвалж болов.

Харин БНХАУ-ын Наран, Ширэм нарын эрдэмтэд 1998 онд бичсэн “Хятад, Монголын харилцааны 45 жил” ном 1949 оноос хойших хоёр орны харилцааны гол үйл явдал, гэрээ хэлэлцээрүүд, хил, хилийн боомт зэрэг эх сурвалж болон лавлах материалуудыг анх хэвлүүлж, товч тайлбар хийжээ.³ Тус бүтээл нь баримт

1 中国对外经济贸易年鉴1984, 北京: 中国对外经济贸易出版社, 1984.

2 中华人民共和国对外经济贸易关系大事记 (1949-1985), 南京: 对外贸易教育出版社, 1987

3 《中蒙关系45年 (1949-1994) 》, 内蒙古科技印刷厂印刷, 1998.

бичгийн эмхтгэлийн шинжтэй бөгөөд Монгол-Хятадын 1949 оноос хойших орчин үеийн харилцааны түүхийн анхны чухал лавлах болжээ.

БНХАУ-д 2006 онд “Нууцаас гаргасан гадаад харилцааны баримтууд – БНХАУ-ын гадаад харилцааны архив 1949-1955 он” бүтээл хэвлэгдэн гарч, уг номонд Хятадын ГХЯ-ны архивын нууцын зэрэглэлээс хасагдсан 1949-1955 онд холбогдох баримтуудыг нийтэлсэн ба үүнд орчин үеийн Монгол-Хятадын дипломат харилцаанд холбогдох зарим шинэ баримт бий.⁴

Орчин үеийн Монгол-Хятадын харилцаанд биеэр оролцож явсан амьд гэрч нараас дурсамж, дурдатгалаа хэвлүүлж эхэлж буйгаас тухайлбал Хятадын дипломатч, монгол судлаач Хуан Зякуйгийн 2008 онд хэвлүүлсэн “Монголд тавантаа: Монгол Улсад хорин жил ажилласан дипломатчийн тэмдэглэл” дурдатгал номыг дурьдаж болно.⁵ Бээжингийн “Дэлхийн мэдлэг” хэвлэлийн газраас эрхлэн, монгол, хятад хэлээр хэвлэн гаргасан “БНХАУ-Монгол Улсын дипломат харилцааны 60 жилийн ой” бүтээлд 1949 оноос хойших тус хоёр улсын улс төр, эдийн засаг, худалдаа, зээл тусламж, парламент солилцоо, хүмүүнлэг, иргэдийн харилцаанд холбогдох олон тооны гэрэл зургийг товч тайлбарын хамт нийтлүүлсэн нь Монгол Улсын талын эх сурвалжаар голчлон бүрдсэн бөгөөд Хятад дахь Монгол-Хятадын харилцааны түүхийн чухал эх сурвалж

болжээ.⁶ Монгол-Хятадын харилцаанд холбогдох он дарааллын лавлахууд монгол, хятад хэлээр хэдэнтээ хэвлэгдсэн нь тус хоёр улсын орчин үеийн харилцааг судлах ажлыг урагш ахиулж байна. 2014 онд Н.Ганбат, Би Аонань нарын монгол, хятад хоёр хэл дээр хэвлүүлсэн Монгол, Хятадын харилцааны он дарааллын лавлахад тус хоёр улсын хооронд дипломат харилцаа тогтоосноос эхлэн улс төр, соёл, боловсрол, эдийн засгийн олон үйл явдлыг багтаасан судалгааны ач холбогдол бүхий лавлах эх сурвалж болон хэрэглэгдэж байна.⁷

Хятадын судлаачид 1990-ээд оноос эхлэн Монголтой холбоотой баримт бичиг, тоон мэдээнүүдийг хэвлэн нийтэлж эхэлсэн бөгөөд үүний үр дүнд 1949 оноос хойших Монгол-Хятадын харилцааг судлах анхан шатны эх сурвалжууд хятад хэл дээр нийтлэгджээ. Эдгээр баримт бичигт тулгуурласан бүтээлүүд нь хоёр улсын судлаачдын хамтын ажиллагаанд тулгуурласан учир Монгол Улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдлыг хүндэтгэж, хоёр улсын найрамдалт харилцааг улам бүр хөгжүүлэх үзэл баримтлал уг бүтээлүүдэд ажиглагдаж байна. Энэ үүднээс тус хоёр улсын хооронд өрнөж байсан 1960-80-аад оны зөрчилдөөний талаар болон түүхийн маргаантай бусад асуудлуудын талаар “дуугүй байх дипломат хязгаар”-ыг сахиж байна.

БНХАУ-д

Монгол-Хятадын

4 《中华人民共和国建交档案：1949~1955》，北京：中国画报出版社，2006年。

5 黄家驊，《五进蒙古：驻蒙外交官二十年工作实录》，呼和浩特：内蒙古大学出版社，2008。Уг ном 2016 онд Улаанбаатар хотод хэвлэгджээ. Жякуй, Х., *Монгол тавантаа: Монгол Улсад хорин жил ажилласан дипломатчийн тэмдэглэл*, Улаанбаатар: 2016.

6 《中蒙建交60周年》，北京：世界知识出版社，2009年。

7 《中华人民共和国和蒙古国国家关系历史编年（1949-2014）》，修订版，北京--乌兰巴托，2014年。

орчин үеийн харилцааг тусгайлан буюу өөр ерөнхий сэдвийн хүрээнд хамруулан авч үзсэн судалгаануудад Монгол Улсыг хэрхэн авч үзэж байгааг ажиглавал, “Монгол Улс бол Хятадын алдагдсан нутаг юм” гэсэн үзэл бодол, байр суурь БНХАУ дахь түүхийн судалгаануудад үргэлжлэн давтагдсаар байна. Үүнд зарим жишээг дурьдвал:

*Гадаад Монголын тусгаар тогтнолын нууц учир (1993).*⁸ Хамтын зохиогчтой. Энэ номноос Хятадын судлаач, өргөн олон нийт Монгол Улсыг хэрхэн үзэж ойлгодгийг тодорхой харж болно. Тус номын гол үзэл агуулга нь Монгол Улс бол Орос-Зөвлөлтийн явуулгаар Хятадаас салж тасарсан ба ХКН-ын удирдагчид “Гадаад Монгол”-ыг эргүүлэн нэгтгэхийн төлөө хичээн эрмэлзэж байсан тухай юм. Номын бичлэгийн арга, хэлбэрийг үзэхэд олон тооны архивын эх баримт, материал, түүхэн бодит хүмүүсийн дурдатгал яриаг ашигласан нь ажиглагддаг боловч баримт, материалуудынхаа эх сурвалжийг тавиагүй тул судалгаанд ашиглахад баахан тохиромжгүй болжээ. Тус ном нь хятадын олон нийгэд зориулагдсан, зарим газарт уран сайхны хэтрүүлэг ашигласан, хялбаршуулсан бичлэгтэй.

*Хятад-Монголын харилцааны шинжилгээ (1949-1965)*⁹. Хятадын Гадаад харилцааны их сургуулийн оюутан Ши Шаосянгийн 2010 онд бичсэн “Хятад-Монголын

харилцааны дүн шинжилгээ (1949-1965)” магистрын дипломын ажил хэмжээгээр жижиг боловч бидний өгүүлэн буй үеийн хоёр улсын харилцаанд холбогдох БНХАУ-ын ГХЯ-ны архивын баримтуудыг өргөн ашигласнаараа бараг анхдагч юм. Мөн тус дипломын ажилд дээр дурьдсан “Гадаад Монголын тусгаар тогтнолын нууц учир” номноос олонтаа ишлэл авч, үзэл баримтлалыг нь шууд дагажээ. Ши Шаосян Гадаад Монгол бол Хятадын алдагдсан нутаг ба 1950-иад онд Мао Зэдун, Жоу Энълай нарын хятадын удирдагчид Сталин, Микоян, Хрущев зэрэг Зөвлөлтийн удирдагчидтай уулзахдаа Гадаад Монголыг Хятадад нэгтгэхээр эрмэлзсээр байсан хэмээн үүнийгээ архивын баримтуудаар нотолжээ.

Бээжингийн Үндэстний их сургуулиас эрхлэн гаргасан “Хятадын хөрш улсуудын танилцуулга” (1994) номын “Монгол Улс” бүлгийн түүхийн хэсэгт “Монголын тал нутаг бол Хятадын (中国) нэг хэсэг, Гадаад Монгол хэмээн нэрлэнэ” гэжээ.¹⁰

Судлаач Лю Вэй 2006 онд “Гадаад Монгол бол Хятадын (中国) газар нутаг, гэвч ХХ зууны эхэнд гадаад ба дотоод хүчин зүйлсийн нөлөөгөөр, ялангуяа Хаант Орос улсын бодлогоор Гадаад Монголын улс төрийн байдалд хэд хэдэн цуврал өөрчлөлт гарч тусгаар тогтносон” хэмээн бичиж байна.¹¹

2009 онд хэвлэгдсэн “Хятад-Оросын харилцааны түүх ба бодит

8 《外蒙古独立内幕》。北京：人民中国出版社，1993。Уг ном 2017 онд монгол хэлээр хэвлэгджээ. *Гадаад Монголын тусгаар тогтнолын нууц учир*, Улаанбаатар: Соёмбо принтинг, 2017.

9 石绍湘，《中蒙关系分析（1949-1965）》，硕士研究生论文，外交学院，2010年。

10 《中国周边国家情况》，北京：中央民族大学出版社，1994，第176页

11 刘威。1911~1919年外蒙的“独立”与“撤治”述论：《科教文汇旬刊》，2006(10)

үнэн” хамтын бүтээлд судлаач Сунь Цайшүнь “Гадаад Монголын тусгаар тогтнолын асуудлыг Хятадын түүхийн судалгаанд удаан хугацааны турш хөндөхгүй орхидог байсан нь түүхийн судалгааны биш, харин улс төрийн асуудал байсанд оршино. Өнөө үед Монгол Улс нэгэн бүрэн эрхт улс болон тогтнож, даруй 60-аад жил өнгөрсөн тул бид зүй нь үүнийг түүхийн нэгэн чухал асуудал болгон үзэхээс гадна реалист задлан шинжилгээ хийж, үүний хамт Чингийн асуудлын мөн чанарыг таних ёстой” гээд үргэлжлүүлэн “Гадаад Монголын тал нутаг бол Хятадын (中国) нутаг дэвсгэр” гэж бичжээ.¹² Түүхийн судалгааны объектдоо реалист, бодит задлан шинжилгээ хийхээр зорьсон судлаач Сунь Цайшүнь болон хятадын дээр дурдсан бусад түүхчид анхны тодорхойлолтоосоо эхлээд Монголын тухай Хятадын (中国) субъектив ойлголтыг баримталж байна.

Үүний хамт БНХАУ дахь түүх бичлэгт Монгол Улсын бүрэн эрхт байдлыг хүндэтгэх үзэл хүчтэй байна. Монгол Улс нь тусгаар тогтносон, бүрэн эрхт улс гэдгийг Хятад дахь орчин үеийн түүх судлаачид судалгаандаа заавал дурьддаг. Энд хятадын түүхч, орчуулагчдын хийсэн нэгэн газрын зургийн залруулгыг жишээ болгон дурдъя.

Кембрижийн их сургуулийн нэр хүндтэй судлаачдын зохиосон “Хятадын кембриж түүх” бүтээлийн

14-р боть – “Ардын бүгд найрамдах улс” номын 1995 оны хэвлэлд 1950-иад оны БНХАУ-ын газрын зургийг зурахдаа Монголыг оруулан ноцтой алдаа гаргажээ.¹³ Тус газрын зураг “Хятадын (中国) физик газарзүй” нэртэй, тодорхой цаг хугацаа заагаагүй ба Оросыг USSR (монг. - ЗХУ) гэж тэмдэглэснээс үзэхэд Кембрижийн түүх зохиогчид үүнийг Чин улсад биш, БНХАУ-д зориулсан нь тодорхой. Энд БНХАУ-ын хилийн дотор Монгол ба Туваг багтааж зурсныг төвөггүй ажиглаж болно. (1-р зураг)

Тэгвэл тус номыг 2007 онд БНХАУ-д орчуулан гаргахдаа БНХАУ-ын хилийг өнөөгийн байгаа хилээр нь зурж, Кембрижийн их сургуулийн бүтээл дэх газрын зургийн алдааг залруулсан (2-р зураг). Энэ нь БНХАУ-ын түүх бичлэгт 1949 оноос хойших Монгол Улсын бүрэн эрхт байдлыг хоёрдмол утгагүйгээр бүрэн хүндэтгэж буйг харуулна.¹⁴

БНХАУ-ын түүхчид 1949 оноос хойших Монгол-Хятадын харилцааг судлах хүрээнд Мао Зэдун, Жоу Энълай нар Монголыг Хятадад нэгтгэхээр эрмэлзсэн тухай сөхөн, “Монгол бол Хятадын (中国) нутаг” хэмээн бичиж байгаа нь өмнө дурдсан эх сурвалж нийтлүүлэх явцад баримталж буй “дуугүй байх дипломат хязгаар”-ыг давж, “Монголын асуудал”-ыг сонирхох сонирхол оршсоор буйг харуулж байна. Үүнээс үзэхэд, БНХАУ дахь түүхийн судалгаанд Монгол-

12 中俄关系的历史与现实 (第二辑), 北京: 社会科学文献出版社, 2009年

13 *The Cambridge History of China, Volume 14, The People's Republic, Part 1: The Emergence of Revolutionary China 1949-1965*, edited by R. MacFarquhar, J. K. Fairbank, New York: Cambridge University Press, 1987, reprinted 1989, 1995.

14 《剑桥中华人民共和国史. 上卷, 革命的中国的兴起: 1949-1965年》, 北京: 中国社会科学出版社, 2007年。

Хятадын орчин үеийн харилцааг авч үзэх түүхэн дэвсгэр нь “Монгол бол Хятадын (中国) алдагдсан нутаг” гэж үзэх явдал хэвээр байна. Монгол Улсын бүрэн эрхт байдал эдүгээ цагт нэгэнт бүрэн баталгаажсан ба үүнд ямарваа улс төрийн маргаан байхгүй тул “Монголын асуудал” нь улс төрийн бус, түүхийн судалгааны асуудал болсон гэж БНХАУ-ын зарим түүхч үзэж байгаа учир энэ тухай судалгаа улам эрчимжиж болзошгүй юм. Мөн үүний зэрэгцээ өнөөгийн Монгол Улсын бүрэн эрхт байдлыг хүндэтгэн үзэх зарчмыг БНХАУ-ын түүхчид 1949 оноос хойших цаг үед хамааруулан тууштай хэрэгжүүлж байгааг онцлох нь зүйтэй.

Монголын ба Зөвлөлт-Оросын үеийн түүхчид “Монгол бол Хятадын (中国) алдагдсан нутаг” гэсэн энэ үзэл бодолд түүхийн шинжлэх ухааны үүднээс олонтаа няцаалт хийж, монголчууд бол хятадтай (中国) хамааралгүй, бие даасан төр улс, түүх, соёл, хэл, аж ахуйтай үндэстэн мөн гэж нотолсоор ирсэн ч БНХАУ дахь түүхийн судалгаанд энэ үзэгдэл яагаад амь бөхтэй оршин байна вэ?

Хятадууд өөрийгөө ухамсарлах нь

Хятадууд өөрсдийгөө болон өөрсдийн төрд харьяалагдах нутаг дэвсгэрийг хэд хэдэн үгээр нэрлэнэ. Хятад (中国), хань (汉), хуася (华夏), дундад газар (中原), тэнгэрийн доорх (天下) зэрэг нь бүгд ямар нэг байдлаар хятадууд өөрсдийгөө болон

өөрсдийн нутаг дэвсгэрийг зааж буй нэр юм. Эндээс бидний хэлэлцэн буй хятад (中国) гэдэг нь “дундад, гол, төв” гэсэн утгатай 中, “улс” гэсэн утгатай 国 гэсэн хоёр ханзнаас бүтэх ба бусад улс, үндэстнээс өөрсдийгөө ялгах зорилгоор өөрийн улсаа нэрлэх хятадуудын этноним юм. Оросын эрдэмтэн С.В.Дмитриев, С.Л.Кузьмин нар хятадуудын өөрийгөө ухамсарлах хятад (中国) гэдэг ойлголт нь Байлдаант улсуудын үеэс эхлэн ХХ зууны эх хүртэл зөвхөн *жинхэнэ хятадыг* зааж байсныг “Юань, Чин болон Хятад нь өөр хоорондоо залгамжлалгүй төр улсууд болох нь” өгүүлэлдээ харуулсан.¹⁵ Үүнийг зарим баримтаар тодрууль.

Сыма Цяний “Түүхэн тэмдэглэл” дэх зарим нэг хийсвэр домгийг эс тооцвол хятадын уламжлалт сэтгэлгээнд Цагаан хэрмийн араар нутаглагч аливаа малчин нүүдэлчин ард түмнүүд хятад (中国) биш, “харь бүдүүлгүүд” бөгөөд тэдний газар нутаг нь ч мөн адил хятад бус, “бүдүүлгүүдийн” тал нутаг юм. Тухайлбал, Баруун Хань улсын үед бичигдсэн күнзийн суртлын “Ёслолын тэмдэглэл” (礼记) бүтээлийн “Вангийн журам” (王制) номд хятад (中国) бол дорно этгээд И (夷), өмнөд этгээд Мань (蛮), өрнө этгээд Жун (戎), умард этгээд Ди (狄) энэ дөрвөн харь ард түмний дунд орших улс бөгөөд энэ таван ард түмэн хэл яриа, хүсэл сонирхол харилцан адилгүй хэмээж, хятадыг (中国) дөрвөн зүгийн хөршүүдээс нь

15 Дмитриев, С., & Кузьмин, С. (2015). Юань, Чин болон Хятад нь өөр хоорондоо түүхэн залгамжлалгүй төр улсууд болох нь. *Studia Historica*, Tomus XLIII-XLIV, Fasc. 16, .

тусгайлан ялгаж тодорхойлсон¹⁶ ба уг зохиолд буй дөрвөн зүгийн хөршүүд нь хятад (中国) гэдэг ойлголтод хамаарахгүй байна.

Хожуу Түрэгийн хаант улсын Культегиний гэрэлт хөшөөний хятад бичээст буй хятад (中国) гэдэг үг мөн адил ямар нэг эргэлзээгүйгээр тухайн үед Цагаан хэрмийн өмнө оршиж байсан хятадын Тан улсыг заадаг. Бичээсийн 2 дахь мөрөнд буй “[Танай дээдэс] уг нутаг нь хятад, умардын тал нутгийг зорьсон” гэсэн утгатай “首自中国, 雄飞北荒”¹⁷ гэсэн өгүүлбэрт буй “хятад - 中国” нь хятадын Тан улсыг, “умардын тал нутаг – 北荒” нь өнөөгийн Монголын нутгийг тус тус зааж буй бөгөөд “雄飞” гэдэг нь “зорин тэмцэх” гэсэн утгатай болно. Энэ өгүүлбэрээс умардын тал нутаг бол хятадаас тусдаа, хятадаас гадна орших, хятад газраас гаран холдож, зорин тэмцэж байж очдог алс хол газар гэдэг нь хялбар ойлгогдоно. Хэдийгээр Культегиний гэрэлт хөшөөн дээрх хятад бичээс хятад төвт үзлийн үүднээс түрэгийн өвөг дээдсийн уугуул нутгийг хятад хэмээн онцолж бичигдсэн боловч Түрэгийн хаант улсын оршин тогтнож байсан өнөөгийн монгол газрыг хятадаас тусдаа, хятадын хил хязгаарт үл харьяалагдах алс холын тал нутаг болохыг тэмдэглэн үлдээсэн баримт

мөн.

Манжийн Чин улсын үед ч хятад мужуудын газар нутаг умард зүгт Цагаан хэрмээр хязгаарлагддаг, өөрсдийгөө хятад хүн гэсэн утгатай 汉人, 中国人 гэж ухамсарладаг, хань хэлээр (汉语) ярьдаг, дотроо умард газар ба өмнөд газар (北方, 南方) хэмээн хуваагддаг 18 мужаас бүрдэх хятад газар (汉地) хэмээх ерөнхий нэртэй байсан бөгөөд товчхондоо хятад нь хятад хэвээр цаг үе байв.

Харин манжийн Чин улсын хаад хятад (中国) гэх нэршлийг дундад улс гэх ханз үсгийн утгаар нь авч ашиглан, хятадын уламжлалтай зөрчилдсөн “Дундад улсыг” үүсгэжээ. Манжийн Чин улсын “Дундад улсын хүн” (中国之人) гэдэг хэллэг нь хятадын уламжлалт “хятад хүн” (中国人) гэдгээс огт өөр агуулгатай, зөвхөн иргэний харьяаллыг заасан үг болсон байв¹⁸. Иймээс манжийн Чин улсын сүүл үед хятадууд 中国人 гэхээс илүүтэй хань хүн (汉人) гэдэг ойлголтыг илүү түгээмэл хэрэглэх болж, ялангуяа манжийн дарлалыг эсэргүүцэж байх үедээ хань үндэстний хятад улсыг байгуулах явдлыг уриа болгон дэвшүүлэх болжээ.

XX зууны эхэнд доктор Сунь Ятсень (孙中山) тэргүүтэй хятадын хувьсгалчид хятадын төрийн уламжлалыг Мин улстай холбож,

16 Эхийг сийрүүлбээс: “中國戎夷，五方之民，皆有其性也，不可推移。東方曰夷，被髮文身，有不火食者矣。南方曰蠻，雕題交趾，有不火食者矣。西方曰戎，被髮衣皮，有不粒食者矣。北方曰狄，衣羽毛穴居，有不粒食者矣。中國、夷、蠻、戎、狄，皆有安居、和味、宜服、利用、備器，五方之民，言語不通，嗜欲不同。達其志，通其欲：東方曰寄，南方曰象，西方曰狄鞮，北方曰譯。”《礼记》：王制，36。

Эх сурвалж: *ChineseText Project*. Web site:

<https://ctext.org/liji/wang-zhi?searchu=%E4%B8%AD%E5%9B%BD&searchmode=showall#n59345>. 2020.06.05.

17 М.Соегов, Новый перевод китайского текста из памятника Кель-тигину: сравнительный подход, // Учёные заметки ТОГУ, 2018, Том 9, №2, с.684-689.

18 Дмитриев, С., & Кузьмин, С. (2015). Юань, Чин болон Хятад нь өөр хоорондоо түүхэн залгамжлалгүй төр улсууд болох нь. *Studia Historica*, Tomus XLIII-XLIV, Fasc. 16, .

харин манжийн Чин улсыг харийн колоничлогчдын төр хэмээн үзэж байв. Хятадын Синьхайн хувьсгалын үндсэн баримт бичиг болсон “Нэгдсэн холбооны тунхагт” (同盟会宣言, 1905) өөрсдийн гол дайсан манжийн Чин улсын “Дайчин улс – 大清” хэмээх албан нэрийг хэрэглэлгүй, харин шууд “манж - 满洲”, “дорнын бүдүүлгүүд - 东胡”, “далю - 鞑虏” хэмээн нэрлэсэн бол өөрсдийн улсыг “хятад - 中国” болон “жунхуа - 中华” гэсэн хоёр нэрээр, өөрсдийгөө “хань хүн - 汉人” хэмээн тус тус нэрлэж бичсэн бөгөөд сэргээн байгуулахыг зорьж буй улсаа “Дундад Иргэн Улс - 中华民国” хэмээн бичжээ.¹⁹

Хятадууд манж, монголыг умардын бүдүүлгүүд, түрэмгийлэгчид хэмээн бүх нийтээр үзэж, ойлгож байсан тэр үед Монгол бол Хятадын (中国) нутаг гэх үг хятадуудын хувьд утгагүй зүйл байсан бөгөөд хятадын нутаг нь хоёр мянган жил уламжлан тогтсон ойлголтын хүрээнд, Цагаан хэрмээс өмнө оршсон хэвээр байв.

XX зууны шинэ хятад (中国)

Өнөөгийн хятадын түүх бичлэгт монгол үндэстэн бол хань үндэстэн биш боловч Хятадын цөөн тоот үндэстэн мөн гэж үздэг. Эндээс XX зууны эхэн үеийн уламжлалт *хятад (1)*, өнөө үеийн өөрчлөгдсөн *хятад (2)* гэдэг хоёр ойлголтын ялгаа тодорно. Энэ хоёр ойлголт хоёул адилхан 中国 гэсэн бичлэгтэй боловч хамрах

хүрээний хувьд 1-р *хятад* нь 汉 гэдэг үгтэй утга давхцах түүхэн ойлголт бол 2-р *хятад* нь 1-р *хятад* дээр манж, монгол, хотон, төвөдийг нэмэн гаргаж ирсэн улс төрийн ойлголт юм. Энэ хувьсал 1911 оны Синьхайн хувьсгалын үеэр эхэлжээ.

Манжийн Чин улсын дарлалаас хятадын ард түмнийг чөлөөлөх хятадын хувьсгалчдын тэмцэл нь нэг талаар харийн дарлагчдыг эсэргүүцсэн үндэстний шинжтэй байсан боловч, нөгөө талаар хаант засгийг халж, бүгд найрамдах засгийг тогтоохыг зорьсон хөрөнгөтний ардчилсан шинжийг давхар агуулж байв.

Сунь Ятсен тэргүүтэй хятадын хувьсгалчдаас 1906-1911 онуудад гаргасан олон тооны эрмэлзэх зүйл, бодлогын бичгүүдэд үндэстний болон ардчилсан хоёр шинж аль аль нь тусч байсан бөгөөд манжийн Чин улсын хүчин буурч, мөхөхөд ойртох тусам тэдгээр хятад хувьсгалчдын үйл ажиллагаанд хятад үндэстнийг харийн дарлалаас чөлөөлөх зорилт бүдгэрч, харин бүгд найрамдах засаг тогтоох зорилт илүү давамгайлсаар эцэстээ 1911 оны Синьхайн хувьсгалын ялалтын үеэр хувьсгалын утга учир нь Хятадад бүгд найрамдах засаг тогтоох, үндэстний эв нэгдлийг хангах явдал болон хувирчээ. Энэ үеэр Сунь Ятсен “Ардын гурван зарчмыг” боловсруулсан бөгөөд уг зарчмын нэгдүгээрт байх “Үндэстний зарчимд” Хятад улс (中国) нь таван үндэстнээс бүрдэх тухай онолыг тунхаглажээ. Энэ таван үндэстний нэгдүгээрт хань

19 1905年8月20日 中国同盟会在东京成立, “人民网资料”. <http://www.people.com.cn/GB/historic/0820/2722.html>. 2020.06.05; *Синьхайская революция, 1911-1913 гг., Сборник документов и материалов*, Москва: Наука, 1968, сс.37-40.

үндэстэн орох ба бусад дөрөв нь манж, монгол, төвд, хотон үндэстэн багтах болов.

Үүний жишээ бол 1912 оны 1-р сарын 1-нд Сунь Ятсен ДИУ-ын Түр Ерөнхийлөгчөөр томилогдоод гаргасан тунхаг юм. Уг тунхагт “Улсын үндэс бол ард түмэн юм. Хань, манж, монгол, хотон, төвөдийн газар нутгийг нэгэн улсад нэгтгэснээр хань, манж, монгол, хотон, төвөдүүд нэгэн гэр бүлд нэгдэн найрамдах бөгөөд үүнийг бид үндэсний нэгдэл хэмээн үзэж байна” хэмээн зарлажээ²⁰. Ийнхүү харийн дарлагчдыг хөөн зайлуулахаар тунхагласан хятадын хувьсгалчдын анхдагч зорилт үгүй болж, оронд нь хуучин дарлагч байсан манж үндэстэн болон бусад дарлагдаж байсан ард түмнүүд нь хамтаар нэг улс гэр болох ёстой гэж тунхаглах болов. Энэ бол өнгөн дээрээ таван үндэстний эрх тэгш Бүгд найрамдах засаг мэт боловч, мөн чанартаа харийн түрэмгийлэгчдийг хөөн зайлуулах гэсэн хятад үндэстний эрх чөлөөний тэмцлээс хэтрэн, хуучин дарлагчдаа хамтдаа дарлагдаж асан ард түмнүүдтэй нь цуг эргүүлэн эзлэн авч, хятадын харьяанд оруулахыг эрмэлзсэн тунхаг байв. Ийнхүү хятадын хувьсгалчдын үйл ажиллагааны үр дүнд ХХ зууны эхэн үеэс эхлэн хятадын олон нийтийн дунд хятад (中国) хэмээх өөрийн ухамсар нь улам бүр өөрчлөгдөн хувьсч эхэлжээ.

Уг тунхагас гурав хоногийн өмнө, 1911 оны 12-р сарын 29-ний өдөр Монгол Улс тусгаар тогтнолоо

тунхагласан бөгөөд Цагаан хэрмийн өмнө байгуулагдсан ДИУ-ыг монголчууд манжийн Чин улстай хамаагүй, зөвхөн хятад үндэстний улс гэж үзсэн ба энэ нь Монголын ба Хятадын түүхэн бодит байдлыг илүүтэй тусгаж байв. Гэвч ДИУ-ын зүгээс Монгол Улсыг шууд өөрийн харьяанд байх ёстой хэмээн үзэж, улмаар 1912 оны 3-р сарын 11-нд батлагдсан ДИУ-ын Түр Үндсэн Хуулийн 3-р зүйлд “ДИУ-ын нутаг дэвсгэр нь 22 муж, Дотоод ба Гадаад Монгол, Төвд болон Хөхнуураас бүрдэнэ” хэмээн заажээ.²¹ Үүнээс хойш 1946 оныг хүртэл ДИУ нь Монгол Улсыг өөрийн нутаг дэвсгэр хэмээн түүхэн бодит байдалд үл нийцэх үзлийг баримталж байв.

1949 онд БНХАУ байгуулагдаж, БНМАУ-тай дипломат харилцаа тогтоов. БНХАУ цөөн тоот үндэстний асуудлыг өөртөө засах хэмжээнд зохицуулж, БНХАУ-ыг 56 үндэстнээс бүрдсэн улс хэмээн зарласан боловч БНХАУ-ын үндэстний бодлогын онолын суурь нь Сунь Ятсений Үндэстний зарчим хэвээр байв. Тухайлбал, 1950-иад онд БНХАУ-ын зарим удирдагч ЗХУ-ын төлөөлөгчидтэй уулзахдаа БНМАУ-ыг БНХАУ-д нэгтгэх талаар нэг бус удаа албан бусаар тандан асууж байв.²² Улмаар энэхүү субъектив ухагдахуун БНХАУ дахь түүхчдийн судалгааны зарчим болон төлөвшсөн байна. Иймээс ч өнөөгийн БНХАУ-ын олон нийтийн үзэл бодолд Сунь Ятсений

20 *Синьхайская революция, 1911-1913 гг., Сборник документов и материалов*, Москва: Наука, 1968, сс.137.

21 *Синьхайская революция, 1911-1913 гг., Сборник документов и материалов*, Москва: Наука, 1968, сс.181.

22 Н.Алтантөгс, *Монгол-Хятадын социалист найрамдлын мандал, буурлын түүх*, Улаанбаатар: МУИС Пресс, 2019, 92-94-р тал.

онол хэвээр үлдсэн төдийгүй, улам бүр лавширчээ. Хятадууд хятадын түүх гэдэгт харийн дарлагч манжийн Чин улс хятадыг дарангуйлан захирч байхдаа бүх эзэнт гүрнээ хамруулан хэрэглэж байсан “Дундад улсын” түүхийг ойлгож, үүндээ Зүүн Азийн эх газрын хятад, монгол, манж, хотон-уйгур, төвдүүдийн түүхийг хамруулах болжээ.

Хятадын түүх бичлэгт байгаа энэ төвөгтэй ойлголт өрнөдийн судлаачдын дунд ч түгээмэл, гэхдээ заримдаа будилж төөрөлдсөн хэлбэрээр тааралдана. Өрнөдийн зарим судлаач манжийн Чин улс, ДИУ, БНХАУ-ын тухай бичихдээ ихэнх тохиолдолд “China” гэдэг үгийг хавтгайруулан хэрэглэсээр ирэхдээ Qing ба China гэсэн хоёр өөр утгатай үгийг ялгаж хэрэглэх явдал дорно дахины ард түмнүүдэд ямар их утга учиртай болохыг тэр бүр чухалд үздэггүй. Тухайлбал, судлаач Пэйн “Эзэнт гүрнүүдийн өрсөлдөөн” бүтээлдээ “Монгол бол хэзээд Хятадын (China) нэг хэсэг байгаагүй юм” гэж бичсэнээ

үргэлжлүүлээд “Чин улсын хожуу үе хүртэл Монгол дахь Хятадын удирдлага (Chinese rule) нь хань үндэстний колоничлолоос (Han colonization) тусгаарлагдсан Шинжаан, Манжуур зэрэг хятад бус (non-chinese) угсаатны цэрэгжсэн буфер нутгийн загварыг баримталж байв”²³ хэмээн бичсэн ба энд “Хятадын удирдлага” нь “хятад биш” угсаатны нутгийг “хань үндэстний колоничлолоос” тусгаарлаж байсан тухай өгүүлсэн нь нэн будлиантай явдал болжээ. Зүй нь тэрээр “Чингийн удирдлага” нь “хань бус” угсаатнуудын нутгийг “хань үндэстний колоничлолоос” тусгаарлаж байсан тухай өгүүлсэн бол зүйд нийцэх биз ээ.

Өрнөдийн судлаачдын тухайд ийм жишээ олныг дурдаж болох ба Хятад гэх ойлголт манжийн Чин улс мөхөх үеэр хувьсаж өөрчлөгдсөний шалтгаан нь тухайн үеийн өрнөдийн улсуудаас Чин улс болон ДИУ-ын талаар явуулсан бодлого, үйл ажиллагаатай ч холбоотой байж болох юм.

Дүгнэлт

Дипломат харилцаа тогтоосноос хойших Монгол-Хятадын харилцааны тухай БНХАУ дахь өнөөгийн зарим судалгааны бүтээлийг тоймлон үзвэл,

1-рт, Хятадын архивын чухал баримт, материалуудыг эргэлтэд оруулах талаар ахиц дэвшил гаргаж байна. Хятадын түүхчид 1949 оноос хойших Монголын түүхийн тухайд Монгол Улсын тусгаар тогтнол, бүрэн

эрхийг хүлээн зөвшөөрөх зарчмыг тууштай баримталж буй.

2-рт, БНХАУ дахь түүхийн судалгаанд “Монгол бол Хятадын алдагдсан нутаг” гэх үзэл баримтлал оршсоор байна.

3-рт, Өнөөгийн БНХАУ-ын түүхчдийн хэрэглэж буй “хятадын алдагдсан нутаг” хэмээх ойлголт нь манжийн Чин улс нуран унах үед

23 Pain, S. C. M., *Imperial Rivals: China, Russia, and Their Disputed Frontier*, New York: M. E. Sharpe, 1996, pp. 276.

хятадын хувьсгалчдаас зориудаар бий болгож, хятадын олон нийтэд үнэмшүүлсэн, улс төрийн түрэмгий зорилго бүхий шинэ ухагдахуун юм.

4-рт, Өрнөдийн зарим судлаачдаас Чин улс ба Хятад улсыг шууд хүчээр адилтгах буюу будилж нэгтгэн бичих үзэл БНХАУ-ын түүх бичлэгийн дээрх хандлагад улам бүр хүч нэмж байна.

5-рт, Сунь Ятсений “Ардын гурван зарчимд” буй таван үндэстний бүгд найрамдах улсын тухай үзэл санаа, түүнд агуулагдсан “үндэстний зарчим” нь Хятад хэмээх үндэстний төр улсыг манж үндэстний Чин улстай хүчээр холбогдуулсан, Монголын ч тэр, Хятадын ч тэр урьдын түүхэн бодит байдалтай үл нийцэх улс төрийн зорилготой онол юм. БНХАУ дахь орчин үеийн түүхийн судлаачид Сунь Ятсений энэхүү онолыг бүтээлүүддээ

зарчмын төвшинд хэрэглэж буй явдал нь Монгол Улсыг Хятадын алдагдсан нутаг хэмээн үзэхэд хүргэж, энэ үзэл нь улмаар монгол, хятадын судлаачдын хооронд ХХ зууны төдийгүй, Монголын бүх түүхийн талаар үл ойлголцол үүсэх уг сурвалж болж байна.


ХХ зуунд хятадын хувьсгалчид манжийн Чин улсын харьяанд байсан ард түмнүүдийг өөртөө нэгтгэх зорилгоор шинэчлэн томъёолсон *хятад* хэмээх ойлголтыг БНХАУ-ын түүхчид өнгөрсөн бүх түүхэн дэх *хятад* хэмээх ойлголт руу буцаан хэрэглэж буй явдал нь нэгэнт өнгөрч одсон эрт цагийн түүхийг хожим үүссэн шинэ ойлголтод үндэслэн гажуудуулж тайлбарлаж буй явдал бөгөөд түүхэн зүйн зарчимд үл нийцэх, улс төрийн зорилготой, субъектив хандлага мөн.

Ашигласан материал

- Н.Алтантөгс, *Монгол-Хятадын социалист найрамдлын мандал, буурлын түүх*, Улаанбаатар: МУИС Пресс, 2019.
- Жякуй, Х., *Монгол тавантаа: Монгол улсад хорин жил ажилласан дипломатчийн тэмдэглэл*, Улаанбаатар: 2016.
- Pain, S. C. M., *Imperial Rivals: China, Russia, and Their Disputed Frontier*; New York: M. E. Sharpe, 1996.
- Дмитриев, С., & Кузьмин, С. (2015). Юань, Чин болон Хятад нь өөр хоорондоо түүхэн залгамжлалгүй төр улсууд болох нь. *Studia Historica*, Tomus XLIII-XLIV, Fasc. 16.
- М.Соегов, Новый перевод китайского текста из памятника Кель-тигину: сравнительный подход, // *Учёные заметки ТОГУ*, 2018, Том 9, №2, с.684-689.
- Синьхайская революция, 1911-1913 гг., Сборник документов и материалов*, Москва: Наука, 1968, сс.137.
- The Cambridge History of China, Volume 14, The People's Republic, Part 1: The Emergence of Revolutionary China 1949-1965*, edited by R. MacFarquhar, J. K. Fairbank, New York: Cambridge University Press, 1987, reprinted 1989, 1995.

- 《剑桥中华人民共和国史。上卷，革命的中国的兴起：1949-1965年》，北京：中国社会科学出版社，2007年。
- 《中蒙关系45年（1949-1994）》，内蒙古科技印刷厂印刷，1998。
- 《中华人民共和国建交档案：1949~1955》，北京：中国画报出版社，2006年。
- 《中华人民共和国和蒙古国国家关系历史编年（1949-2014）》，修订版，北京--乌兰巴托，2014年。
- 《外蒙古独立内幕》。北京：人民出版社，1993。*Гадаад Монголын тусгаар тогтнолын нууц учир*, Улаанбаатар: Соёмбо принтинг, 2017.
- 石绍湘，《中蒙关系分析（1949-1965）》，硕士研究生论文，外交学院，2010年。
- 《中国周边国家情况》，北京：中央民族大学出版社，1994。
- 刘威．1911~1919年外蒙的“独立”与“撤治”述论：《科教文汇旬刊》，2006(10)。
- 中俄关系的历史与现实（第二辑），北京：社会科学文献出版社，2009年。


Хавсралт



1-р зураг.

(The Cambridge History of China, Volume 14, The People's Republic, Part 1: The Emergence of Revolutionary China 1949-1965, 1995)

Монголын орчин үеийн түүхийн талаар БНХАУ-ын түүхчдийн баримталж буй үндэстний зарчмыг шүүмжлэх нь



2-р зураг.

(剑桥中华人民共和国史。上卷，革命的中国的兴起：1949-1965年，2007)

Defining the principles of nationalism of Chinese historians in relation to modern Mongolian history

Altantugs Namjilchoijil

*Teacher (Ph.D.), Department of History, National University of Mongolia,
Ulaanbaatar, Mongolia*

E-mail: xarizmatika@hotmail.com

Abstract: *In this article, we tried to discuss on the ideological background that “Mongolia was part of China (中国)”. This idea is repeated in the academic publications about contemporary Mongolian history in the Peoples’ Republic of China. According to the first principle “Nationalism” of the “Three Principles of the People” by Sun Yat-sen (Sun Zhongshan), mongolians are one of five nations in China (中国). But, this idea doesn’t correspond with the real conditions of Mongolian and Chinese (中国) history. Chinese historians’ conception of the term of China (中国) as Qing dynasty (清朝) was one of main causes of historical misunderstanding between Mongolian and Chinese historians.*

Keywords: *Mongolia, China, Three Principles of the People.*

The day of submission: 2020.5.19

Completion of review: 2020.6.3

Final decision for acceptance: 2020.6.7